

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ГЕОЛОГИЙН САЛБАР – 50 ЖИЛД

Х.Уламбадрах, Ж.Бямба, Л.Жаргал, Б.Бат  
Монгол Улсын Их Сургууль, Геологийн салбар

*Түлхүүр үг: МУИС, геологи, геологийн салбар, дээд боловсрол*

### Хураангуй

Монгол улсад 20-р зууны хагасаас эхлэн геологи шинжилгээний ажил эрчимтэй өрнөж эхэлснээр өсөн нэмэгдэж байгаа мэргэжилтний хэрэгцээг дотоодын боловсон хүчнээр хангах шаардлага гарч ирсэн бөгөөд үндэсний геологийн сургалтыг зохион байгуулсан нь Монголын геологийн салбарын хөгжилд томоохон түлхэц болсон байна.

1960 оны 4-р сарын 11-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн ба МАХН-ын Төв хорооны 171/112-р тогтоолын дагуу тухайн ондоо МУИС-ийн БУФ-ийн Газар зүйн 3-р ангиас 13 оюутныг Геологийн 3-р анги болгон авч, шинээр 39 оюутан элсүүлэн хичээллүүлж эхэлснээр Монгол улсад Геологийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлжээ. 1969 онд МУИС-ийн харьяанд Политехникийн Дээд Сургууль (ПДС) байгуулагдсанаар бүтцийн өөрчлөлт хийгдэж Геологийн салбар Геологи, Уул Уурхайн Факультет (ГУУФ) болон өргөжсөн ба 1982 онд ПДС нь МУИС-иас бие даан салсанаар МУИС Геологийн ангигүй болжээ.

Монгол улсын ууган их сургууль МУИС-д Геологийн анги зайлшгүй байх шаардлагаар 1991 онд МУИС-ийн Ректорын тушаал гарч, тухайн оны 4-р сарын 1-нд БУФ-ийн дэргэд Геологийн тэнхим байгуулагдаж Газарзүйн салбарын II дамжаанаас 6 оюутан шилжүүлэн сургалтын ажлыг эхлүүлснээр МУИС-д геологийн мэргэжилтэн бэлтгэх хоёр дахь үе шат эхэлсэн юм. 1992 оноос Геологийн салбарын багшлах боловсон хүчин, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор өргөн мэдлэг боловсрол, үйлдвэрлэлийн дадлага туршлагатай эрдэмтэд, судлаачдыг багшаар ажиллуулж ирлээ. Тэнхимийн багш нар Монголын геологи, геодинамик, стратиграфи, тектоник, ашигт малтмалын геологи, петрографийн судалгаа, үлэг гүрвэлийн морфологи хөгжил, ангилал зүй, улиран хувьслын онолын судалгаа, ашигт малтмалын ордын нөөцийн тооцоо, эдийн засгийн үнэлгээ, мөн зайнаас тандан судлал, газрын доорх усны экологи, нүүрсний геологи, шатах ашигт малтмалын геохими, структур геоморфологийн чиглэлүүдээр ажиллаж, олон арван бүтээл туурвижээ. Эрдэм шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор Геологи, эрдэс баялгийн судалгааны төв байгуулагдан ажиллаж байна.

МУИС-иар “овоглогдох” нийт 1203 геологич байдгийн 482 нь 1963-1982 онд төгссөн бол үлдсэн 721 геологич мэргэжилтнийг сүүлийн 15 жилд төгсгөжээ. МУИС-ийн Геологийн салбарын цаашдын зорилт нь улсын болон сургуулийн зорилтот бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэй нягт холбоотой төлөвлөгдсөн юм.

## Оршил

Монгол улсад 20-р зууны хагасаас эхлэн геологи шинжилгээний ажил эрчимтэй өрнөж нүүрс, газрын тос, алт, зэс, вольфрам, хайлуур жонш зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын ордуудыг шинээр нээн илрүүлж, уул уурхайн үйлдвэрүүд шинээр байгуулагдаж эхэлснээр өсөн нэмэгдэж байгаа мэргэжилтний хэрэгцээг дотоодын боловсон хүчнээр хангах шаардлага гарч ирсэн бөгөөд үндэсний геологийн сургалтыг дахин зохион байгуулсан нь Монголын геологийн салбарын хөгжилд томоохон түлхэц болсон байна.

Одоогоор МУИС-ийн Геологийн салбар, ШУТИС-ийн Геологи, Газрын тосны сургууль, Дарханы Техникийн сургууль, Газарчин дээд сургууль, Ховд их сургуульд геологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа боловч сургалтын гол үйл ажиллагаа МУИС, ШУТИС-д төвлөрч байна. Сүүлийн жилүүдэд Монголын геологи, уул уурхайн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, дэлхийн нэр хүнд бүхий томоохон компаниуд хүч түрэн орж ирж байгаагийн хирээр орчин үеийн техник технологи ашиглах болон өндөр нарийвчлалтай лабораторт ажиллах чадвартай, онолын өндөр мэдлэгтэй мэргэжилтэнг бэлтгэх нь нэн тэргүүний эрхэм зорилго болж байна.

МУИС-ийн Геологийн салбар нь одоогоор 18 багш, 2 туслах ажилтантайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа ба геологи, эрэл хайгуул; шатах ашигт малтмалын геологи, эрэл хайгуул; геологи эрдэс баялгийн менежментийн чиглэлээр бакалавр, магистр, докторын шаталсан сургалтаар мэргэжилтэн бэлтгэж байна.

Монгол улсад Геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 50 жилийн ой тохиож байгаа энэ өдрүүдэд төгссөн сургуулиараа “овоглогдон” ажиллаж байгаа нийт геологчиддоо мэндчилгээ дэвшүүлэхийн ялдамд 1991 онд МУИС-д Геологийн тэнхим дахин байгуулагдсанаас хойшх сургалт, эрдэм шинжилгээний ажлын хөгжлийг түүхэн байдлаар доор оруулав.

### МУИС-ийн Геологийн салбарын түүхэн хөгжил

1960 оны 4-р сарын 11-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн ба МАХН-ын Төв хорооны 171/112-р тогтоолын 3-р зүйлийн а хэсэгт “Улсын геологийн ажлыг үндэсний мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилгоор Чойбалсангийн нэрэмжит Улсын Их Сургуулийн Газар зүйн салбарын 1, 2-р ангийг түшиглүүлэн, 1960-1961 оны хичээлийн жилээс Геологийн салбар байгуулан хичээллүүлэхийг Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн /н.Б.Лхамсүрэн/-д даалгасугай.” гэж заасны дагуу тухайн ондоо МУИС-ийн БУФ-ийн Газар зүйн 3-р ангиас 13 оюутныг Геологийн 3-р анги болгон авч, шинээр 39 оюутан элсүүлэн хичээллүүлж эхэлснээр Монгол улсад Геологийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлжээ. Анхны багшаар тухайн үеийн СнЗ-ийн дэргэдэх Геологи шинжилгээний газрын ахлах геологич Ж.Дүгэрсүрэн Газар зүйн тэнхимд харьяалагдан ажиллаж эхэлсэн бол 1961 оны эхээр Геологи шинжилгээний газрын геологич Р.Барсболд, Ж.Лхамсүрэн нарыг үндсэн багшаар авч, мөн ЗХУ-аас уригдан ирсэн Петербург хотын Уул уурхайн институтын доцент, дэд эрдэмтэн К.М.Малкова, Львов хотын Их Сургуулийн доцент, дэд эрдэмтэн Ю.Ф.Пекун нар ажилласнаар Геологийн тэнхим (эрхлэгч Ж.Дүгэрсүрэн) байгуулагдаж биеэ даасан салбар болон хөгжжээ. Геологийн тэнхимийн эрхлэгчээр 1962-1965 онд Р.Барсболд, 1966-1967 онд С.Дэмбэрэлдорж, 1967 онд Ж.Ган Очир нар ажиллаж байжээ. Геологийн салбар нь бүтэц, зохион байгуулалт, сургалтын хувьд харьцангуй бэхжиж, 1963 оны эхээр Минералогичи –

петрографийн тэнхим байгуулан өргөжүүлж эрхлэгчээр нь Ж.Лхамсүрэн 1967 он хүртэл ажилласан байна.

1967 онд МУИС-д зарим бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбоотойгоор Геологийн салбар БУФ-аас Газар зүйн салбартай хамт салж МУИС-ийн Геологи Газар зүйн Факультет байгуулагдсан ба тус факультетийн деканаар Ж.Лхамсүрэн, тэнхимийн эрхлэгчээр С.Дашдаваа нар 1969 он хүртэл ажиллажээ.



### Самдангийн Дашдаваа (1937-2005)

Профессор, доктор С.Дашдаваа 1963 онд МУИС-ийг геологийн зураглал, эрэл хайгуулын чиглэлээр төгссөн ба МУИС, ПДС-д багш, тэнхимийн эрхлэгч, декан, сургалт эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байжээ. 1977 онд “Их хайрханы вольфрамитын ордын геологи, гарал үүслийн онцлог” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Тэрээр геологийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх үйл ажиллагаанд бүхий л амьдралаа зориулсаны хамт ховор металлын ордын бодисын бүрэлдэхүүний судалгаагаар ажиллаж байсан байна.

1969 оны 7-р сарын 17-ны БНМАУ-ын СнЗ-ийн 247 тоот тогтоолоор МУИС-ийн харьяанд Политехникийн Дээд Сургууль (ПДС) байгуулагдсанаар бүтцийн өөрчлөлт дахин хийгдэж Геологийн салбар Геологи, Уул Уурхайн Факультет (ГУУФ) болон өргөжжээ. ГУУФ нь МУИС-ийн харьяанд 1982 он хүртэл байсан ба энэ хугацаанд Ж.Лхамсүрэн (1969-1971), С.Дашдаваа (1971-1972), Я.Болд (1972-1976), Н.Шийтэр (1976-1977), О.Гомбо (1977-1978), А.Самдан (1978-1982) нар деканаар, С.Дашдаваа (1969-1971), Ж.Лхамсүрэн (1971-1972, 1972-1976), Я.Болд (1972), Ж.Ган Очир (1976-1978), О.Гэрэл (1978-1982) нар тэнхимийн эрхлэгчээр ажиллажээ.



### Ядамсүрэнгийн Болд (1940-2003)

Доктор, профессор Я.Болд 1966 онд МУИС-ийг геологийн зураглал, эрэл хайгуулын чиглэлээр төгссөн ба төгссөнөөсөө хойш МУИС, ПДС-д багш, тэнхимийн эрхлэгч, деканаар ажиллаж байжээ. 1985 онд “Жанчивлангийн хүдрийн зангилааны шороон орд үүссэн структур – геоморфологийн нөхцлүүд” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Я.Болд нь Монгол улсад геологийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, геоморфологийн судалгааны суурийг тавихад үнэтэй хувь нэмэр оруулжээ.

ГУУФ –д 1972 онд Уул уурхайн тэнхим (тэнхимийн эрхлэгч Б.Ишмэнд (1972-1982)), 1975 онд Гидрогеологийн тэнхим (тэнхимийн эрхлэгч Я.Болд (1975), Н.Батсүх (1975-1982)), 1980 онд Геодезийн тэнхим (тэнхимийн эрхлэгч А.Дамдинсүрэн (1980-1982))-үүдийг шинээр байгуулж байжээ.

1982 оны 7-р сарын 21-ний МАХН-ын Төв Хорооны 227-р тогтоолоор ПДС нь МУИС-иас бие даан салсанаар МУИС Геологийн ангигүй болжээ. МУИС-ийн Геологийн салбарын 1982 он хүртэлх сургалт, эрдэм шинжилгээ, бүтэц, зохион байгуулалтын дэлгэрэнгүй түүхийг ШУТИС-ийн ГГТС-ийн профессор багш нар өмнө нь удаа дараа бичсэн учраас энд дахин нурших нь илүүц бизээ.

Монгол улсын ууган их сургууль МУИС-д Геологийн анги зайлшгүй байх шаардлагаар МУИС-ийн Ректорын 1991 оны 4-р сарын 9-ний “Геологийн тэнхим

нээн ажиллуулж, багш шилжүүлэх тухай” 266 тоот тушаал гарч, тухайн оны 4-р сарын 1-нд БУФ-ийн дэргэд Геологийн тэнхим байгуулагдсанаар МУИС-д геологийн мэргэжилтэн бэлтгэх хоёр дахь үе шат эхэлсэн юм.

Иймээс Техникийн Их Сургуулийн Геологи-минералогийн тэнхимээс Проф. С.Дашдаваа, Дэд проф. Я.Болд, хичээлийн туслах ажилтан М.Цагаанхүү нар томилогдон ирж шинэ салбарын сургалтын үйл ажиллагааг МУИС-ийн БУФ-ийн Газарзүйн салбарын II дамжаанаас 6 оюутан шилжүүлэн эхлүүлж байжээ.

1992 оноос Геологийн салбарын багшлах боловсон хүчин, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор өргөн мэдлэг боловсрол, үйлдвэрлэлийн дадлага туршлагатай эрдэмтэд, судлаачдыг үндсэн болон цагийн багшаар урьж ажиллуулж байлаа. Газрын тос, шатах ашигт малтмалын геологийн чиглэлээр мэргэшсэн ш.у-ы док. Д.Бат-Эрдэнэ, док. Я.Цэдэнбалжир, Д.Жанчив, Геологи-эрдэм баялагийн чиглэлээр ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн эрдэмтэд ш.у-ы док. Д.Доржнамжаа, док. Ж.Бадамгарав, док. Г.Бадарч, док.П.Хосбаяр, док. С.Ариунбилэг, ТИС-ийн геологийн салбарын эрдэмтэн багш нар проф. О.Гэрэл, проф. Д.Чулуун, проф. Ж.Цэвээнжав, проф. Г.Ухнаа, проф. П.Дугараа, проф. С.Дандар, Чимэдцэрэн, ГТЛ-ийн инженерүүд Б.Батжаргал, Т.Алтанцэцэг, Л.Жаргал, Ц.Өлзий-Очир, геофизикч С.Лантуу, Ганбаатар нарын багш нар мэргэжлийн голлох хичээлүүдийг зааж байжээ.

#### **Жамбын Бямба (1940 онд төрсөн)**



Шинжлэх ухааны доктор, профессор Ж.Бямба 1965 онд Москвагийн Геологи – Хайгуулын Дээд Сургуулийг төгсчээ. 1991 онд “Монголын хожуу протерозой – түрүү палеозойн тектоник хөгжил ба эртний фосфоритын хуримтлал явагдсан геологийн нөхцөл” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Монгол орны геодинамик хөгжил, фосфорит хуримтлал болон геологийн зураг зүйн хөгжилд үнэт хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. “Монголын эртний стрүктүрүүд ба тэдгээрийн фосфорит агууламж”, “Монголын геологи ба ашигт малтмал” бүтээлийн IV боть болох “Литосферийн плитийн тектоник” зэрэг хэд хэдэн томоохон бүтээлүүдийг туурвижээ.

Геологийн тэнхимийн бүтэц бүрэлдхүүн өргөжиж 1993 оноос Д.Оюунцэцэг (1996 он хүртэл), док. Б.Бат, 1994 оноос док.А.Пэрлээ, ш.у-ы док. Д.Бат-Эрдэнэ (2005 он хүртэл), 1995 оноос док.Л.Жаргал, 1996 оноос ш.у-ы док. Ж.Бямба, 1998 оноос док. Д.Доржготов (2009 он хүртэл), 2006 оноос док. С.Авирмэд нар ажиллаж ирлээ. Төгсөгчдөөс 1995 оны төгсөгч Н.Мөнхбилэг, С.Хүрэлбаатар, 1997 оны төгсөгч С.Оюунгэрэл, Н.Одгэрэл, Н.Байгалмаа, 1998 оны төгсөгч Б.Эрдэнэцогт, 2000 оны төгсөгч Х.Уламбадрах, 2001 оны төгсөгч Д.Нансалмаа, 2003 оны төгсөгч В.Доржмаа, 2005 оны төгсөгч Л.Оюунжаргал нар багшлах ажил хийж ирэв.

Геологийн тэнхимийн эрхлэгчээр С.Дашдаваа (1991-2001, 2004-2005), Л.Жаргал (2001-2004, 2005-2007), Д.Доржготов (2007-2009), Х.Уламбадрах (2009 оноос) нар ажиллаж иржээ.

МУИС-ийн Геологийн салбарыг өргөжүүлэх, Монгол орны геологийн салбарт эн тэргүүнд шаардагдаж байгаа мэргэжилтнүүдээр хангах зорилгоор Геологи, эрдэм баялгийн менежментийн ангийг 2003 оноос нээн хичээллүүлж эхэлсэн ба энэ ангийн хичээл сургалтын ажилд голлон док. С.Авирмэд, З.Ганбаатар нар оролцож ирлээ.



**Дэлэгийн Бат Эрдэнэ (1942 онд төрсөн)**

Шинжлэх ухааны доктор, профессор Д.Бат Эрдэнэ 1967 онд Эрхүүгийн Политехникийн Дээд Сургуулийг төгсчээ. 1992 онд “Монголын ороген структур дэх нүүрс агуулсан хотгоруудын үүссэн нөхцөл, байршлын зүй тогтол” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Монгол орны нүүрс, шатдаг занар, газрын тос зэрэг шатах ашигт малтмалын геологийн хөгжилд хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Шатах ашигт малтмалын чиглэлийн сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрийг гардан боловсруулснаас гадна “Монголын шатах ашигт малтмал” зэрэг хэд хэдэн томоохон бүтээлүүдийг туурвижээ.

Геологийн мэргэжилтэн бэлтгэхэд хээрийн ба үйлдвэрлэлийн дадлага ихээхэн чухал ач холбогдолтой байдаг. 1999-2001 оны хооронд БНХАУ-ын Бээжингийн Их Сургуультай гэрээ байгуулж оюутны дадлага БНХАУ-д хийж байсан нь, мөн Москвагийн Геологи, Хайгуулын Дээд Сургуулийн сургалтын хөтөлбөрийг жишээ болгон бүх ангиуд жил бүр дадлага хийдэг болсон нь оюутнуудын дадлагыг үр өгөөжтэй болгох, танхимд суралцсан геологийн мэдлэгийг батжуулах, сургалтын олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал алхам болсон юм.



**Алтангэрэлийн Пэрлээ (1945 онд төрсөн)**

Доктор А.Пэрлээ 1968 онд МУИС-ийг геологийн зураглал, эрэл хайгуулын чиглэлээр төгссөн. 1991 онд “Гүрвэл аарцагт динозаврын аарцаг болон хойд хөлийн бүтцийн харьцуулсан морфологийн судалгаа ба хөдөлгөөний онцлог” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Эрдэм шинжилгээний гол ажил нь үлэг гүрвэл судлах ажилд зориулагдсан ба нийт 7 зүйлийн үлэг гүрвэлийг шинээр нээж, бүтээлүүдээ Английн Nature, Америкийн Science болон Орос, Польш, Канад зэрэг оронд хэвлүүлсэн XXI зууны шилдэг эрдэмтдийн нэг юм.

Профессор С.Дашдаваа ховор металлын ордын судалгаа, профессор Я.Болд ашигт малтмалын ордын судалгаанд структур геоморфологийн арга ашиглах чиглэлээр ажиллаж байсан бол профессор Ж.Бямба Монголын геологи, геодинамик, тектоникийн чиглэлээр, профессор Д.Бат Эрдэнэ Монгол орны шатах ашигт малтмалын геологийн судалгаагаар, профессор Л.Жаргал Монгол орны нүүрсний ордуудын петрографи, седиментологийн чиглэлээр, профессор А.Пэрлээ үлэг гүрвэлийн морфологи хөгжил, ангилал зүй, улиран хувьслын онолын судалгаагаар, доктор Д.Доржготов Монгол орны полиметаллын хүдэржилт, формацийн ангилал, металлогены судалгаагаар, доктор С.Авирмэд ашигт малтмалын ордын нөөцийн тооцоо, эдийн засгийн үнэлгээний чиглэлээр ажиллаж, олон арван бүтээл туурвижээ.

Тэнхимийн багш нараас доктор Б.Бат зайнаас тандан судлал, газрын доорх усны экологийн чиглэлээр, доктор Б.Эрдэнэцогт нүүрсний геологи, шатах ашигт малтмалын геохимийн чиглэлээр, С.Оюунгэрэл алтны ордын минералоги, минераграфийн судалгаагаар, Х.Уламбадрах Монгол орны структур геоморфологийн судалгаагаар, В.Доржмаа седиментологийн чиглэлээр, Н.Байгалмаа шатах ашигт малтмалын геологи, петрографийн судалгаагаар ажиллаж судалгааны ажил хийж байна.



**Дангиндоржийн Доржготов (1948 онд төрсөн)**

Доктор Д.Доржготов 1975 онд МУИС-ийг геологийн зураглал, эрэл хайгуулын чиглэлээр төгссөн. 1996 онд “Дорнод Монголын мезозойн вулкан – плутон бүсийн хар тугалга – цайрын хүдэржилт” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Говь Угтаал, Баян жаргалан, Дорнодын хүдрийн дүүргүүдийн хүдрийн формац, комплекс, тархалт, байршлын зүй тогтлоор ажиллаж, түүний үр дүнгээр олон арван эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлжээ.

Эрдэм шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор Геологи, эрдэс баялгийн судалгааны төв (эрхлэгч Ж.Бямба)-ийг байгуулан ажиллаж байна.

МУИС-иар “овоглогдох” нийт 1203 геологч байдгийн 482 нь 1963-1982 онд төгссөн бол үлдсэн 721 геологч мэргэжилтнийг сүүлийн 15 жилд төгсгөжээ.

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан геологич Д.Тогтох, Л.Мөнхтогоо, Д.Гарамжав, төрийн шагналт геологч С.Цэрэн Очир, В.Довжид, Д.Гунгааням, зохиолч Д.Батбаяр, гавьяат тамирчин, шатрын олон улсын хэмжээний мастер Л.Мягмарсүрэн болон Ч.Эзбум, Я.Болд, Ж.Ган Очир, Д.Чулуун, Ш.Батжаргал, С.Дандар, А.Пэрлээ, Ш.Батжаргал, Ж.Бадамгарав, Г.Дэжидмаа, Г.Бадарч, Д.Доржготов, Б.Дэлгэрцогт, Т.Семейхан, Д.Товуудорж, Л.Жаргал нарын 14 хүн докторын зэрэг хамгаалжээ. Мөн зураглалын Ш.Лхүндэв, Х.Далилхан, Ч.Цэдэнбал, Ц.Баатар, И.Ниндэвгомбо зэрэг, ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгаанд үнэт хувь нэмэр оруулсан Д.Баадай, Э.Болд, Б.Алтан Очир, Н.Ням, Д.Даваасамбуу, Д.Дашцэрэн, Н.Авид, Б.Бэгзсүрэн, С.Алтангэрэл, М.Дамдинбат, Ч.Чимэддорж, Д.Пүрэвдорж, Ж.Сумъяа, Т.Намсрай, Д.Жанчив зэрэг, геологийн байгууллагыг удирдаж байсан С.Сономцэвээн, Ч.Хуажин, Г.Болд, Б.Гүрлхаажав, С.Должин, Ш.Баасандорж, Б.Батжаргал, Д.Чилхаажав, Т.Сэнгэдорж, Л.Базарсад, С.Энхцаг зэрэг, орлогч сайд асан Д.Санжаадорж, А.Баасанжав, тэргүүний уран сайханч Д.Машлай, сэтгүүлч Н.Өлзийбат зэрэг олон арван геологичид бол МУИС-ийн бахархал юмаа.

Манай төгсөгчдийн дотроос Д.Гунгааням, В.Довжид, С.Цэрэн-Очир нар Заамрын дүүрэг, Ерөөгийн савд алтны ордын судалгааг үр бүтээлтэй явуулж, нөөц өсгөхөд оруулсан хувь нэмрийг үнэлж Төрийн шагнал хүртжээ.



Төрийн соёрхолт  
геологич С.Цэрэночир



Төрийн соёрхолт  
геологич В.Довжид



Төрийн соёрхолт  
геологич Д.Гунгааням

Геологч Д.Тогтох, Л.Мөнхтогоо, Д.Гарамжав нар геологийн зураглалын ажилд, нүүрсний ордын эрэл хайгуул хийж нөөц өсгөхөд, Оюу толгойн ордыг нээх, судлахад оруулсан ололт амжилтыг өндрөөр үнэлж Аж үйлдвэрийн гавъяат ажилтан цолоор тус тус шагнаж ирсэн юм.



Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Д.Тогтох



Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Л.Мөнхтогоо



Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Д.Гарамжав

Мөн салбартаа ажиллаагүй ч гэсэн утга зохиолын салбарт оруулсан амжилтыг үнэлж геологч Д.Батбаярыг төрийн шагналаар, геологч, олон улсын шатрын мастер Л.Мягмарсүрэн гавъяат тамирчин цолоор тус тус шагнагдаж байсан билээ.

МУИС-д геологч мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн 2 дахь үе буюу 90-ээд онд Монгол улс зах зээлийн нийгэмд шилжиж, төрийн байгууллагууд хувьчлагдаж, мөн шаталсан сургалт явагдаж эхэлсэнтэй холбоотойгоор геологич мэргэжилтэн бэлтгэх сургалтын үйл ажиллагаа бүрэн өөрчлөгдсөнийг тэмдэглэх нь зүйтэй.

1994 онд Монгол улсад анх удаа Газрын тосны геологч мэргэжлээр Г.Ган-Отго, Г.Сандуйжав, Б.Баянжаргал, Ч.Эрдэнэ нарын 4 мэргэжилтэн бэлтгэгдэн гарсан билээ. 1995 оноос Геологи, эрэл хайгуул болон Газрын тосны геологич мэргэжлээр нийт 5 төгсөгч, 1996 оноос эхлэн Геологи, эрэл хайгуул болон шатах ашигт малтмалын эрэл, хайгуулын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн гаргаснаас хойш тасралтгүй өнөөг хүртэл төгсөлт явагдаж, энэ хугацаанд геологи, эрэл хайгуулын чиглэлээр 384, шатах ашигт малтмалын геологи, эрэл хайгуулын чиглэлээр 247, геологи, эрдэс баялгийн менежментийн чиглэлээр 90 хүн бэлтгэгдэн гарчээ.

Төгсөгчдөөс Б.Баатарцогт, Б.Эрдэнэцогт, Т.Оюунчимэг нар докторын зэрэг хамгаалж их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад үргэлжлүүлэн ажиллаж байгаа бол Ц.Барсболд, Г.Ган Отго, Б.Зул, Ч.Алтанзул, Л.Байгалмаа, Т.Отгонбаяр, Ч.Ганзүрх, В.Арслан, Н.Ганбат, Д.Батням, Н.Жавхлан, Г.Ганхуяг нарын зэрэг олон арван геологчид төрөл бүрийн ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг хийж, нөөц бодож ашиглалтанд хүлээлгэн өгөх чухал шаардлагатай ажлуудад үр бүтээлтэй ажиллаж байна. Түүнчлэн Геологийн төрийн байгууллагуудад үр бүтээлтэй ажиллаж байгаа Г.Сандуйжав, П.Хүрэлхүү, Б.Сүнжидмаа, А.Амаржаргал, Ц.Минжинсор, А.Мөнхтөр нарын зэрэг геологчид байна.

## ЦААШДЫН ЗОРИЛТ

МУИС-ийн Геологийн салбарын цаашдын зорилт нь МУИС-ийн Стратеги төлөвлөгөө, Геологи Газар зүйн Сургуулийг 2015 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөтэй нягт холбоотойгоор төлөвлөгдсөн юм. Үүнээс заримыг дурьдвал,

- “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын Боловсролын хөгжлийн бодлого, Геологи, эрдэс баялгийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн олон улсын стандартад уялдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох,

- Монгол улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, Монгол улсад дээд боловсролыг 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд заагдсаны дагуу багш, судлаачдад дэмжлэг үзүүлэх,

- Эрдэм шинжилгээний тэргүүлэх ба дэд хөтөлбөрт тусгагдсан геологи, эрдэс баялгийн чиглэлийн судалгааны ажлуудыг эхлүүлэх,

- Үндэсний хэмжээний судалгааны төв, геологийн түүхэн музей, танхим байгуулах,

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбар дундын хөтөлбөр, лаборатори бий болгох зэрэг байна.

Монгол улсад геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн Геологийн салбар байгуулагдсан өдрөөс эхлэн геологичдыг бэлтгэх ажилд гар бие оролцон ажиллаж байсан ахмад болон одоо ажиллаж байгаа нийт багш нар, МУИС-ийн нэрээр овоглон Монгол орны нийт нутаг дэвсгэрийн геологийн иж бүрэн судалгаанд оролцож, бүх масштабын геологийн зураглалыг гардан гүйцэтгэж, ашигт малтмалын олон арван орд газрыг нээн илрүүлэн олборлолтонд шилжүүлж, улс орныхоо хөгжил дэвшил, бүтээн байгуулалтанд нэр хүндтэйгээр оролцсон, одоо ч үргэлжлүүлэн оролцож байгаа нийт төгсөгч геологчиддоо баяр хүргэж, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

### Ашигласан хэвлэл

**Болд Л**, Монголын геологийн өнөөгийн байдал, цаашид баримтлах бодлого, чиглэл, 2005. Геологийн асуудлууд, №222 (07), Улаанбаатар, х. 5-13

**Дашдаваа С, Профессор Чулуун Д, 2005.** Хэрлэнгийн геологийн экспедиц. Геологи, №12, Улаанбаатар, х. 14-16

**Дашдаваа С, Лааган Б, 1989.** Политехникийн дээд сургуулийн түүхэн замнал. Улаанбаатар, (хэвлэгдээгүй)

**Дашдаваа С, Оюунгэрэл С, 2001.** Монголын геологийн судалгаанд МУИС-ийн Геологийн салбарын төгсөгчдийн оруулсан хувь нэмэр. Геологийн асуудлууд, №3-4, Улаанбаатар, х. 448-454

**Дашдаваа С, Гэрэл О, Лхамсүрэн Ж, Чулуун Д, 2000.** МУИС-ийн багш дэд профессор Я.Болдын сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа. Геологи ба байгаль орчин, Улаанбаатар, х. 3-6

**Жамъяндорж Ө, Бямба Ж, 2009.** Монголын геологийн салбарын түүхийг бүтээлцсэн жирийн геологчид. Геологийн асуудлууд, №326 (10), Улаанбаатар, х. 5-19

**Лхамсүрэн Ж, 1999.** Монголын геологчид шинжлэх ухааны салбарт. Монголын геосудлаач, дугаар 4, Улаанбаатар, х. 72-82

**Лхамсүрэн Ж, Батсүх Н, Цэвээнжав Ж, Чулуун Д, 2000.** Геологийн сургууль-40. Улаанбаатар,

**Пэрлээ А, 2006.** Нэгэн жарны өнгөнд. Геологийн асуудлууд, №270 (08), Улаанбаатар, х. 7-13